



ХЭНТИЙ АЙМГИЙН ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧИЙН ТУШААЛ

2025 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/08

Өмнөдэлгэр сум

Хоолны зардлыг олгох тухай

Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.3 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх хэсэг, Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”, 2025 оны батлагдсан төсвийн хүрээнд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын төрийн албан хаагчийн хоолны зардлын тодорхой хэсгийг байгууллагаас нөхөн олгох тогтоол, журмыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын ажилтан, албан хаагчийн нэг өдрийн хоолны зардлын нөхөх төлбөрийн дээд хэмжээг орон нутагт 5,000 төгрөг, тухайн сарын ажлын өдрөөр тооцоход орон нутагт 107,500 төгрөг (сард дунджаар), 2024 оны цалингийн төсвийн үлдэгдэл болон 2025 оны батлагдсан төсөвтөө багтаан олгосугай.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг нягтлан бодогч (Л.Сарантуяа)-д үүрэг болгосугай.

ЭРХЛЭГЧ



О.ГАНЦЭЦЭГ

232510040